


## Монгол Улсын “Гуравдагч хөрш”- ийн бодлого: Туршлага ба асуудал - Монгол, Туркийн харилцаа

Зохиогч: Доктор Ч.Цэрэннадмид  
Редактор: Доктор (Sc.D), профессор Л.Хайсандай  
Хэвлэсэн газар: Удам Соёл хэвлэлийн газар  
Хэвлэсэн он: 2020



Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын нэг чухал чиглэл болсон “Гуравдагч хөрш” - ийн бодлого, үзэл баримтлалын хүрээний Евроазийн бүс нутаг дахь чухал түнш орны нэг Бүгд Найрамдах Турк Улс ба Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагааны тухай өгүүлэх “Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого: Туршлага ба асуудал - Монгол, Туркийн харилцаа” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг тус хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрхлэгч, доктор Ч.Цэрэннадмид сүүлийн 10 орчим жил дагнан хийсэн судалгааныхаа үр дүнд тулгуурлан туурвижээ.

Бүтээлийн Нэгдүгээр бүлгийг бичихдээ зохиолч судалгааны онол, арга зүйн үндэслэлийг орчин үеийн бодлого судлалын ухааны онол, үзэл баримтлалд тулгуурлан боловсруулсан тухай, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын үүсэл хөгжил, утга учир, онцлог, онол, үзэл баримтлалын хүрээ зэргийг тоймлон харуулахыг зорьжээ.

Хоёрдугаар бүлэгт Турк Улсыг бүс нутгийн нөлөө бүхий тоглогч болгож буй шалтгаан, хүчин зүйлсийг Турк Улсын бүсчилсэн гадаад бодлого, ялангуяа геостратеги, геополитикийн үндсэн чиглэлүүдээр нь дамжуулан тодруулахыг зорьсоноос гадна Бүгд Найрамдах Турк Улсын гадаад бодлогын уламжлал, шинэчлэл, Төв Азид чиглэсэн бодлогын онцлогийг тайлбарлажээ. Бүлгийн төсгөлд Турк Улсыг Монгол Улсын “гуравдагч хөрш” болгож буй шалтгаан, хүчин зүйлийг тодорхойлж, тус бодлогод Турк Улсын эзэлж буй байр суурь гүйцэтгэх үүрэг, хоёр орны хоорондын иж бүрэн түншлэлийн харилцааны төлөв байдалд дүн шинжилгээ хийсэн байна.

Гуравдугаар бүлэгт ХХ зууны эхэн үед буюу 1920-иод оны түүхэн цаг үед тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан орчин үеийн Монгол Улс ба Турк Улсын хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг түүхэн үндэс, дипломат харилцаа тогтоож хөгжсөн, сүүлийн 50 гаруй жилийн үйл явцад тулгуурлан тодорхойлж, Монгол ба Туркийн хоёр талт харилцаа, хамтын ажиллагааны хүрсэн бодит үр

дүнг гадаад бодлогын үндсэн чиглэлүүдээр дүн шинжилгээ хийжээ. Чингэхдээ Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хамтын ажиллагааны түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэж, өнөөгийн гадаад бодлого, иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг түншлэлийн дараагийн шат руу ахиулахад тулгамдаж буй гол асуудал, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд цаашид хэрэгжүүлж болох хамтын ажиллагааны чиглэл, боломжуудын талаар дурдсан байна.